

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл DPUB

Мэдээллийн эмхэтгэл № 7 (2018 он 1-р сар)

Зам, тээврийн хөгжлийн яамны дэд зөвлөлийн хурал

2018.01.24

1-р сарын 22-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны ХБИ-ийн эрхийг хангах дэд зөвлөлийн хуралдаан болж, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хэлэлцэн баталлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг сургалчлан таниулах, нисэх онгоцны буудал, агаарын тээврийн компанид ХБИ-ийг ажиллуулах, хүртээмжийн үнэлгээг зохион байгуулах, автобус, галт тэргээр ХБИ зорчих боломжийг нэмэгдүүлэх гэх мэт олон үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр болсон бөгөөд JICA DPUB төслийн зүгээс холбогдох албан хаагчдад мэдлэг ойлголт өгөх, хүртээмжтэй орчныг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулахаар боллоо. ХБИ-ийн эрхийг хангах дэд зөвлөл нь яам бүр дээр албан ёсоор байгуулагдсан бөгөөд ХБИ-ийн Төрийн бус байгууллагуудын төлөөлөл, төрийн албан хаагчид хамтран ХБИ-ийн бодлого, төлөвлөгөөний талаар хэлэлцдэг. Тус зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах ба жилийн эцэст үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхээр төлөвлөж байна. Энэ мэтчилэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид заасан ХБИ-ийн бодлогын зөвлөл Монгол улсад бодитоор хэрэгжиж байгаа нь томоохон ахиц юм. DPUB төслийн зүгээс ч гэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, олон нийтийн тээвэр болон зам, явган хүний зам зэрэг ХБИ-ийн нийгмийн оролцоонд саад учруулж байгаа хүчин зүйлүүдийг арилгах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах болно.

2018.01.16

Төслийн зүгээс дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг сайжруулах чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтран үйл ажиллагаа явуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ (зүүн), Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ(баруун) нартай уулзалдлаа. Уулзалтын үеэр төрийн нарийн бичгийн дарга төмөр зам, нисэх онгоцны буудлын хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэн ХБИ-д ээлтэй орчныг бүрдүүлэх, ХБИ-ийн ажлын байрыг бий болгохын тулд хүчин чармайлт гарган ажиллана хэмээн өгүүлж байлаа. Төслийн ахлах зөвлөх Чиба төслийн үйл ажиллагааг танилцуулснаас гадна Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтаар дамжуулан хүмүүсийн ухамсар ойлголтыг өөрчлөх нь чухал гэдгийг уламжиллаа. Цаашид ЗТХЯ-тай амжилттай хамтран ажиллана гэж найдаж байна.



НҮБ-д дадлага хийх боломж олдсон нь



DPUB төслийн ахлах зөвлөх Чиба Хисао

Австралид магистрын зэргээ амжилттай хамгаалаад НҮБ-д ажилд орно гэсэн сайхан мөрөөдөлтэй байсан хэдий ч НҮБ-д ажилд орох нь тийм ч амар хялбар зүйл биш байлаа. Тиймээс юуны өмнө дадлага хийх өргөдөл гаргахаар болсон юм. Хаана, яаж өргөдөл гаргахаа ч сайн мэдэхгүй байсан тул эхлээд НҮБ-ын талаар судлах хэрэг гарсан. НҮБ-ын талаар судлаад үзтэл хэдийгээр нэг байгууллага боловч дотроо мэргэжлийн байгууллага, агентлагууд гэх мэт олон бүтэц, үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдгийг ойлгосон юм. Гэсэн хэдий ч нарийн ширийн зүйлийг нь сайн ойлгоогүй тул ямар ч байсан Нийгмийн хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг UNDP, UN Төв оффис, UNESCAP гэсэн 3 газарт өргөдлөө явуулахаар боллоо. Тэнцэх магадлал ер нь бага байдаг гэж сонсож байсан учраас тухайн үедээ нэг их найдлага тавиагүй. Харин хаана ажиллахаа одооноос шийдэхгүй болохгүй нь дээ... гэсэн бодолтойгоор Тайланд руу аялалаар явсан. Тэгээд Японд буцаад иртэл UNESCAP-аас дадлага хийх боломжтой гэсэн хариу ирсэн байлаа. НҮБ-ын Ази Номхон далайн Эдийн засаг, Нийгмийн комисс буюу UNESCAP-т дадлага хийх өргөдөл явуулахаасаа өмнө ийм байгууллага байдаг эсэхийг нь ч мэддэггүй байсан надад ирэх 7 хоногоос дадлагаа эхлүүлнэ үү гэсэн хариу ирсэн байсан тул шуудхан онгоцны билетээ худалдаж аваад ямар ч бэлтгэлгүйгээр Тайландыг зорьлоо. Тухайн үед надад хамт сурч байсан Тайланд найз маань их тус болсон нь одоо ч мартагддаггүй.

Ингээд НҮБ-д дадлагажигчаар ажиллах эхний өдөр ирлээ. Урьд нь телевизээр л хардаг байсан НҮБ-ын барилга өмнө минь сүндэрлэн байхыг хараад “хөөх... ямар гоё юм бэ” гэж гайхширч байсныгаа одоо ч тодхон санаж байна. Тэгээд би Нийгмийн хөгжлийн хэлтсийг хайн очлоо. (Үргэлжлэл бий...)



JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1107** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээлүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Тайландын ХБИ-ийн хөдөлгөөний талаар танилцууллаа !

~ Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуучуудад зориулсан 4 дэх удаагийн хичээл ~

2018.01.25



Сургалтын үеэр

Энэ удаагийн хичээлээр зүүн өмнөд Азийн чийглэг дулаан уур амьсгалтай Тайланд улсын ХБИ-ийн хөдөлгөөний талаар лекц орлоо. Төслийн ахлах зөвлөх Чиба Тайландад 5 жил амьдарч байсан юм. Тус хичээлээр Тайландын ХБИ бага хэмжээний бүлгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан тухай, мөн бүх ХБИ-ийн төлөө ажиллах ХБИ-ийн зөвлөл (Council of Disabled People of Thailand ; DPI Тайланд) -ийг байгуулан өөрийн орны хууль эрхзүйн орчныг сайжруулахын төлөөх үйл ажиллагаагаа эхлүүлсэн үйл явцын талаар танилцууллаа. Түүнчлэн Тайландын хөгжлийн бэрхшээлийн салбарын хөгжил дэвшлийн түлхүүр нь юундаа байсан талаар хэлэлцүүлэг хийсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч нарын оролцоо, бусад улс орны талаарх “мэдлэг ойлголт”, мөн донор байгууллагуудтай амжилттай хамтран ажилласан гэх мэт олон учир шалтгааны талаар ярилцлаа. Дараагийн цуврал хичээлээр Филиппиний ХБИ-ийн хөдөлгөөний талаар танилцуулах болно. 2-р сарын 21-ний өдөр дахин уулзацгаая!

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээллийн хүртээмж

~ Улаанбаатар хотын төв номын сангийн Хүртээмжтэй технологийн төвтэй танилцлаа ~

2018.01.30

1-р сарын 29-ний өдөр Улаанбаатар хотын төв номын сангийн Хүртээмжтэй технологийн төвийн мэргэжилтэн Цэнгэлтэй уулзалдлаа. Тэрээр өөрөө харааны бэрхшээлтэй бөгөөд “Текстэн мэдээллийг явал унших боломжтой эсэх, IT-ийн технологийг ашиглах ямар арга байдаг” талаар олон жил судалгаа хийж иржээ. Одоо өөрийн сурсан мэдсэн зүйлээ бусаддаа түгээн, харааны бэрхшээлтэй иргэдэд мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. Өнөө үед харааны бэрхшээлтэй иргэд текстэн мэдээллийг дуу хоолой руу хөрвүүлэх боломжтой компьютерийн NVDA программыг монгол хэлээр ашиглан word, excel гэх мэт апплейкшүүдийг хэрэглэхийн зэрэгцээ цахим хуудсуудаар зочлох боломжтой болжээ. Цэнгэл “Өөр олон харааны бэрхшээлтэй иргэдэд IT технологийн талаар танилцуулж мэдээллийн ялгаатай байдлыг арилгахыг хүсдэг!” хэмээн өгүүлж байлаа. Мөн тус төвд компьютерийн хэрэглээний талаар суралцаж буй Лувсандорж “NVDA-г ашиглан олон төрлийн мэдээлэл авах болсноор мэдлэгийн хүрээгээ тэлэх боломжтой болсон” хэмээн өөрийн сэтгэгдлээ хуваалцлаа.



Уулзалтын дараа дурсгалын зураг татуулав

ХБИ-ийн бие даан амьдрах эрх

2018.01.26

Монгол улсад Түгээмэл хөгжил гэх мэт ХБИ-ийн бие даан амьдрах төвүүд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Нөгөөтэйгүүр ХБИ бие даан амьдрахад нэн шаардлагатай туслах ажилтны нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдээгүй байгаа нь томоохон асуудал юм. Японы Mainstream холбоо /бие даан амьдрах төв/ нь Монголын бие даан амьдрах төвийг дэмжин, нягт хамтын ажиллагаатай байдаг. Энэ утгаараа Монголын өнөөгийн нөхцөл байдлын талаар санал солилцохоор JICA DPUB төслийн мэргэжилтнүүдтэй уулзалдлаа. Төслийн зүгээс “Монгол улсын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээлэл”-ийг танилцууллаа. Мөн Зүүн Өмнөд Азийн хөгжиж буй орнуудтай харьцуулахад Монгол улсад нийгмийн хамгааллын тогтолцоо харьцангуй сайн бүрдсэн байдаг, Монголын ХБИ маш идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг талаар ярилцсан. Түүнчлэн хэдийгээр нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдсэн байгаа ч тэтгэвэр, халамжийн мөнгөний хэмжээ бага тул туслах ажилтны зардлыг хувь хүн өөрөө гаргах боломжгүй гэдгийг уламжиллаа. Бие даан амьдрах гэдэг нь “Ямар ч хүнд хэлбэрийн бэрхшээлтэй байсан 『Өөрийн орон нутагтаа бусдын л адил амьдрах』 явдал юм. Өөрөөр хэлбэл бусдын санаа бодол, бололцоо зэрэгт тохируулан амьдрах бус, өөртэй нь холбоотой аливаа асуудалд өөрөө бие даан шийдвэр гаргаж амьдрах”-ыг хэлнэ. (Mainstream холбооны цахим хуудаснаас авав.) Цаашид Монголын ХБИ-ийн бие даан амьдрах орчин улам сайжирна гэдэгт найдаж байна.



Дурсгалын зураг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com